



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 1/33

Рашаант сум

Г Т

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоолын 3.8 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Зудын эрсдлийг бууруулах хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор малчин өрх бүрт аймгаас татаж ирсэн тэжээлийг хүргэх, малын хорогдлын мэдээ судалгаа, өвс тэжээл, хүнсний нөөцийн судалгаа гаргах зорилгоор багт ажиллах, отор нүүдлийн айл өрхүүдэд мэдэгдэл хүргэх, багийн хурал зохион байгуулах, Цэнгэлийн голын халиа тошин боох, мөсөн болон шороон далан босгох, мөс шуудуулахад зарцуулсан шатахууны зардал болох 5,841.300 (таван сая найман зуун дөчин нэгэн мянга гурван зуу) төгрөгийг Орон нутгийн нөөц хөрөнгөнөөс зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас зарцуулахыг санхүүгийн албаны дарга (Н.Нандин-Эрдэнэ), ЗДТГ-ын нягтлан бодогч (Э.Хажидмаа) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын ЗДТГ-ын дарга (Т.Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ